

Нялгын Савын Зарим Хэсэгт Шатдаг Занарын Баялгийг Дахин Үнэлсэн Үр Дүнгээс

Б.Эрдэнэцогт, Л.Жаргал, Н.Байгалмаа


МУИС, ШУС, Геологи, геофизикийн тэнхим

ХУРААНГУЙ

Одоо мөрдөгдөж буй ангиллаар, Монгол улсад шатдаг занарын 13 савыг ялгагдаг ба эдгээр савуудад шатдаг занараас гадна газрын тос, байгалийн битум, нүүрсний хэвтэш, ордууд байрлана (Зураг 1а). Өмнөх судлаачид Монгол орны бүх шатдаг занар доод цэрдийн хурдастай холбоотой гэж үзэж байсан [2] боловч сүүлийн үеийн судалгаагаар зарим шатдаг занар агуулсан хурдсын нас дунд юра болохыг тогтоогоод байна [4]. Дунд юра болон доод цэрдийн шатдаг занарууд нь I төрлийн керогентэй, хүхрийн агуулга багатай (0.1%-1.5 %). Юрийн шатдаг занарын органик нүүрстөрөгчийн агуулга (ТОС) <33.2 %, харин доод цэрдийн шатдаг занарын ТОС 35.6 % хүрч байна [3].

Монголын шатдаг занар болон шатдаг занарын давирхайн баялагийг Бат-Эрдэнэ, Жаргал нар (1994) үнэлсэн байдаг. Шатдаг занарын баялагийг тухайн үед тодорхой хэмжээгээр судлагдаад байсан 9 сав, 3 илрэлийн хэмжээнд 788 тэрбум тонн, харин давирхайн баялагийг 4 сав, 2 илрэлийн хэмжээнд 22.7 тэрбум тонн гэсэн байдаг. Энэ нь шатдаг занарын савуудын нийт талбайн 19.2%-д шатдаг занарын баялгийг, 7.8%-д давирхайн баялгийг тус тус үнэлсэн гэсэн үг юм.

Сүүлийн жилүүдэд Төв Монголын хэмжээнд, хэд хэдэн шатдаг занарын савуудад бидний гүйцэтгэсэн судалгааны үр дүнд зарим шинэ мэдээлэл цуглараад байна. Энэхүү мэдээлэлд тулгуурлан Нялгын савын Дэрэнгийн дэд савын хэмжээнд шатдаг занар болон түүний давирхайн баялгийг үнэлсэн үр дүнг илтгэлд өгүүлнэ. Энэхүү үнэлгээнд геологийн зураглал, хүндийн хүчний судалгаа, өрөмдлөг, лабораторийн задлан шинжилгээний үр дүнг ашигласан болно. Өмнө нь Дэрэнгийн дэд савын шатдаг занарын баялгийг 7.1 тэрбум тонн гэж үнэлээд, харин лабораторийн задлан шинжилгээ дутмаг тул давирхайн баялгийг үнэлээгүй байсан юм.



Зураг 1а. Монголын шатдаг занарын сав, орд, илрэлүүд (Бат-Эрдэнэ, 2009-аас авч засварлав).
 Савууд: LAB – Нууруудын хотгор, GAB – Говь-Алтай, ORB – Онгийн гол, TGB – Төгрөг, ULB – Өгий нуур, UJB – Өвөржаргалант, NGB – Нялга, MGB – Дундговь, SGB – Өмнөговь, EGB – Дорноговь, SBB – Сүхбаатар, TAB – Тамсаг, CHB – Чойбалсан; Орд/илрэл: 1 – Баянтээг, 2 – Цагаан-Овоо, 3 – Хөөт, 4 – Шарыngoл, 5 – Эрдэнэ-Уул, 6 – Баянцагаан, 7 – Гацуунгол, 8 – Сухай, 9 – Бахар-Уул, 10 – Андхудаг, 11 – Төгрөг, 12 – Эрдэнэ, 13 – Хөгшингол, 14 – Зүүнбулаг, 15 – Өвөржаргалант, 16 – Төхөмнуур, 17 – Эрэнговь, 18 – Нарийн-Уул, 19 – Царсанчулуут, 20 – Өвдөгхоолойн гашуун, 21 – Налайх, 22 – Эрэнговь, 23 – Өлзийтнуур, 24 – Бээлийнжас, 25 – Шаварт-Овоо, 26 – Нүхт, 27 – Хөхцаа, 28 – Нэргүй, 29 – Хашиаатхудаг, 30 – Жирмийнхудаг, 31 – Шинэ-Ус, 32 – Хавхастай, 33 – Нэргүй, 34 – Замын-Үүд, 35 – Хар эрэг, 36 – Шорвогнуур, 37 – Төгрөг, 38 – Баян-Эрхэт, 39 – Баянжаргалан, 40 – Овоосүм, 41 – Хөлөнбуйр, 42 – Бухынхудаг, 43 – Мэлхийхудаг, 44 – Цагааннуур, 45 – Амны худаг.

Зураг 1б. Шатдаг занарын баялаг үнэлсэн сав, дэд сав, орд илрэлүүд (Бат-Эрдэнэ, Жаргал нар, 1994)

ИШЛЭЛ

1. Бат-Эрдэнэ Д., “Шатах ашигт малтмал. Монголын геологи ба ашигт малтмал”, Боть V. УБ, 2009, х.178-270.
2. Бат-Эрдэнэ Д., Жаргал Л., “Монголын шатдаг занар, түүний хэтийн төлөв”, УБ, 1994
3. Erdenetsogt B., Jargal L., “Fossil fuels hosted in Mesozoic sequences of Mongolia”, 2nd International Symposium of IGCP Project 608, Tokyo, Japan, Proceeding of the symposium, 2014, p.135-138.
4. Li G., Ando H., Hasegawa H., Yamamoto M., Hasegawa T., Ohta T., Hasebe N., Ichinnorov N., “Confirmation of a Middle Jurassic age for the Eedem Formation in Dundgobi Province, Southeast Mongolia: constraints from the discovery of new spinicaudatans (clam shrimps)”, *Alcheringa*, 2014, 38, 305-316.